

Ч.Оюунбилэг, Д.Ариунаа, Х.Ариунаа,
Ш.Ариунчимэг, Ж.Ууганцэцэг

ХӨГЖИМ

IV

Ерөнхий боловсролын сургуулийн
4 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2020 он

DDC
371.32
X-545

Хөгжим IV: Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийн сурах бичиг.
/Оюунбилэг Ч., ба бус; Ред. Баттогоо Ш., -УБ.2014. -67х

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөршөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал хүсэлтийг textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99973-69-69-7



БИД ЮУ СУРАХ ВЭ?



ДУУЛЪЯ



СОНСЪЁ



ХӨГЖИМДЬЕ



БУЖИГЛЭЕ



ЗОХИОН
НАЙРУУЛЪЯ

ГАРЧИГ

Монгол Улсын төрийн дуулал	5	Удиртгал хөгжим	42
Шинэ өглөө	6	Бодол	42
Хорвоо амгалан байг	7	Монгол ардын дууны хувилбар аяз	43
Анд нөхөдтэйгөө хамт явахад	8	Хөгжмийн энгийн хэлбэрүүд	44
Нуугдаж тоглоцгооё	9	Тоохуу нэгэн хос	45
Гурван охин	10	Twinkle twinkle little star	45
Имж	11	Шөнө	45
Арслангийн марш	12	Тооройн цагаан элс	46
Марш	13	Эхийн дуу	46
9-р сарын 1	15	Уралдаан	47
Заан	16	Тогорууны бүжиг	48
Шинэ он	19	Таягт	49
Цасан охин хаачсан бэ?	20	Өөрийгөө сориорой	50
Болжмор	21	Говийн өглөө	53
Шинэ оны хүсэл	22	Тайгын орой	54
Хөх яргуй	23	Арав дахь эрдэнэ	55
Ган зам	24	Түүдэг гал	56
Эльфүүдийн бүжиг	26	Руслан Людмила хоёр	57
Прелюди	27	V симфони	58
Өргөөний баяр наадам	28	Үзэсгэлэнгийн зураг	58
Уран илэрхийллийн аргууд	29	Черноморын марш	59
Хөгжимдье	30	Хэнтийн өндөр ууланд	60
Дөрвөд биелгээ	32	Бяцхан ангаахайн бүжиг	61
Хамтдаа бүжиглээ	33	Би цэцэг тарьсан	62
Зохион найруулъя	34	Хичээлийн завсарлагааны дуу	62
Өөрийгөө сориорой	36	Жигмэд Тогмид хоёр	63
Хэнз хурга	37	Хосоороо бүжиглээ	64
Нэг ангийнхан	38	Хүндэтгэлийн бүжиг	65
Өглөөний тухай дуу	39	Зохион найруулъя	66
Цэцэг юм уу би	40	Өөрийгөө сориорой	68
Бүүвэйн дуу	41		

ӨМНӨХ ҮГ

Хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе!

Хүүхдүүд ээ, та нар өмнөх ангиуддаа хөгжмийн эгшиг аялгууг бичиж тэмдэглэх ноот бичлэгтэй танилцаж, ноотоор дуулан, хөгжмийн зэмсгээр хөгжимдөж сурах алхмаа хийсэн билээ.

Харин энэ хичээлийн жилд хөгжим хүний амьдралын мөнхийн дагуул байж, баярлах, гуних гээд бүх л сэтгэл хөдлөл, бодол санааг илэрхийлэн, ямар ч зүйлийг дүрслэн, зураглаж чаддаг болохыг мэдэж авна. Энэ бүхэнд тодорхой арга хэрэглүүрүүд хэрэгтэй болох нь мэдээж. Эдгээртэй танилцахын зэрэгцээ хөгжмийн бүтээл нь тодорхой хэсгүүдээс бүрдэх бөгөөд энэ хэсгүүд нэгэн бүхэл болон нэгдэж дүрслэл, илэрхийлэлд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг ойлгох болно.

Өөртөө олон оньсого, нууцыг хадгалж байдаг хөгжмийн утга агуулгыг мэдэрч, ойлгож, өөрийн уран бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэн, амьдралыг олон талаас нь таньж мэдэхэд хөгжмийн сурах бичиг та нарт тусална.



Үг. Ц.Дамдинсүрэн

ДУУЛЬЯ

Ая. Б.Дамдинсүрэн, Л.Мөрдорж



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДУУЛАЛ

Хүндэтгэлтэй

Дар - хан_ ма - най_ тус - гаар у - лас Да - яар_ Монго - лын_ а - риун го - ломт Да - лай их дээд - сийн гэ - гээн үй - лэс Дан-даа энх-жиж үү - рд_ мөнх-жи - нө Ха - маг дэл-хийн шу-дарга улс - тай Хамт-ран нэгд-сэн э - вээ бэх - жүүл -жээ Ха - тан зо - риг бү - хий чад-лаа-раа Хайр-тай Мон-гол ор - ноо ман-дуул - яа яа

Өндөр төрийн минь сүлд ивээж
 Өргөн түмний минь заяа түшиж
 Үндэс язгуур хэл соёлоо
 Үрийн үрдээ өвлөн бадраая

Эрэлхэг монголын золтой ардууд
 Эрх чөлөө жаргалыг эдлэв
 Жаргалын түлхүүр хөгжлийн тулгуур
 Жавхланта манай орон мандтугай



- Төрийн дууллаа сонсоод дагаад дуулаарай.
- Төрийн дууллаас ямар сэтгэгдэл төрсөн бэ? Доорх үгсээс сонгоорой.
 - Баяр баясгалантай
 - Хүндэтгэлтэй
 - Бодлогоширонгуй
 - Уйтгартай
- Сонгосон хариултаа тайлбарлаарай.
- Төрийн дууллыг ямар үед дуулдаг вэ?
- Өөр улсын төрийн дууллыг сонсоод харьцуулаарай.



ШИНЭ ӨГЛӨӨ

Цоглог

Нарны алтан цацраг шинэхэн
 Навчинд унасан шүүдэр шинэхэн
 Найз нөхдийн бодол шинэхэн
 Намуун өглөө дандаа шинэ

Унших номын хуудас шинэхэн
 Уянгат дууны аялгуу шинэхэн
 Багачууд бидний яриа шинэхэн
 Баярт өглөө дандаа шинэ

Цэгтэй ноот лига легато синкоп хэмнэл

- Дууны бадаг дахилтын аялгуунаас чамд ямар мэдрэмж төрж байна вэ? Доорх зураглалыг ашиглан тайлбарлаарай.



Бадаг

Үүрийн шувуудын жиргээ шинэхэн
 Үүлээ арчсан тэнгэр шинэхэн
 Үлээх салхины амьсгаа шинэхэн
 Өглөө болгон дандаа шинэ

...?



Дахилт

Шинийг хайх эрлийн өглөө
 Шинийг хийх урмын өглөө
 Шинийг нээх хүслийн өглөө
 Шинийг авчрах энхийн өглөө

Уянгын зөөлөн, дуулалт шинж
 төрхийг илэрхийлнэ.



ХОРВОО АМГАЛАН БАЙГ



Марш

Al - tan элс - ний шир - хэг бү - хэнд Ах на - рын минь мөр_үлд - сэн

5 Тэн - гэр - лэг үйл - сийн э - зэд тэд цөм_а - мьд_бай - гаа

9 Тэн - гэр - лэг үйл - сийн э - зэд тэд цөм_а - мьд_бай - гаа

Аюулт дайныг амиараа хаасан
Ах минь та үхээгүй ээ
Наран үдлэх хоймортоо
Надтай хамт үүрд байгаа

Гамшиг тарьсан хар дайны
Галаар тургисан буун дуу
Хүүхэд биднийг бүү айлгаг
Хүний хорвоо амгалан байг



- Тусгайлан тэмдэглэсэн хэсэгт аялгууны нугалааг хөнгөн цэвэр хийгээрэй.
- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Давталттай хэсэг байна уу?
- Дараах зураглалаас “Хорвоо амгалан байг” дууны аялгууны бүтцийг ажиглаарай.

A.

A.

B.

B.

B.

B.



АНД НӨХӨДТЭЙГӨӨ ХАМТ ЯВАХАД



Цоглог

5

Анд нө - хөд минь цуг я - ва - хад Ая - ны зам ч хөг-жил - тэй

Анд нө-хөд минь хамт я - ва - хад Аа - дар бо - роог ч тоох - гүй

9

Найз нө - хөд - гүй бол чи

Найз - тай бол чи

13

Найз - тай бол чи ба - яр жар - гал - тай

Анд нөхөд минь цуг явахад
 Айх аюул ч байхгүй
 Анд нөхөд минь хамт явахад
 Санасан хүслээ бүтээнэ

Найз нөхөдгүй бол чи
 Уйтгар гунигтай
 Найзтай бол чи
 Баяр жаргалтай

- Аялгууны шинж төрхийг шүлгийн утга санаатай холбон ярилцаарай.
- Дууны тусгайлан тэмдэглэсэн хэсгийг хэмнэлээр тогшиж дуулаарай.



Аа-дар бо-роо ч тоох - гүй

уйт-гар гу-ниг-тай


- Дуулахдаа хэмнэлийн хамсраа хийгээрэй.

2/4



НУУГДАЖ ТОГЛОЦГООЁ

Халиунаа гэдэг охинтой нуугдаж тоглож байна гэж төсөөлье. Зөндөө тоглолоо. Даанч Халиунааг хайгаад хайгаад олсонгүй. Тэр хаана нуугдчихваа? Түүнийг олон янзаар дуудъя.



ААВ ХҮҮ ХОЁР (Наргиантай шүлэг)

- Ааваа би өнөөдөр
Авдар дээрээс уначихсан
- Тэгээд миний хүү яав
Тэнгэр доргитол орилов уу?
- Үгүй үгүй, би уйлаагүй
Өрөөнд хэн ч байгаагүй

Хэл ярианд утга санаагаа
бүрэн ойлгуулахын тулд дуу
хоолойныхоо өнгийг дээшлүүлж,
доошлуулж өөрчлөхийг аялга
гэнэ.

- Шүлгийг нэг өнгөөр, нэг хурдаар, нэг л янзаар яг шулуун шугам шиг уншаад үз.
- Шүлгийн утга санаа болон аав хүү хоёрын дуу хоолойн өнгийг илэрхийлж, дүрд хувирч уншаарай. Ямар ялгаатай байна вэ?
- Аялгыг дүрсээр илэрхийлж болох уу?



Мөн “за” гэдэг үгийг гайхсан, уурласан, үл тоомсорлосон, захирсан гэх мэт янз бүрийн аялгаар хэлээд үзээрэй. Эдгээр авиа болон үгийн шинж төрх нь бидний сэтгэл хөдлөлийн байдлаас шууд шалтгаалж байгааг ажиглаж болно.



СОНСЪЁ

- Сэтгэл хөдлөлийг өнгө будгаар илэрхийлж болох уу?
Жишээ нь: Шар өнгө – баярласан,
Саарал өнгө – гунигласан
- Янз бүрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн дүр төрхийг тохирох өнгийн цаасан дээр зурж, тодорхойлж бичээрэй.



Баярласан











Д.Кабалевский

ГУРВАН ОХИН

- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Сонсохдоо зохиолын нэрийг сайтар бодоорой.
- Аялгууны шинж төрхийг тодорхойлцгооё.
- Чиний бодлоор энэ хөгжмөөр хүний ямар зан төрхийг дүрсэлж байна вэ? Ярилцаарай.
- Сонсож таньсан дарааллаараа дугаарлаарай.

Удаан уйтгартай



?

Хөнгөн цоглог




?

Хөнгөн



?





- Дараах дуунуудыг сонсоод аялгууны шинж төрхийг тодорхойлж ярилцаарай.

Үг. Б.Чимиддорж

Ая. Ц.Нацагдорж

БАЛЧИР НАСНЫ НӨХӨР

Музыкальная запись в 4/4 такте. Под нотами текст: Ши-рээ тал-даа лан-дас со-рих-доо Шин-жээч у-яа-чийн эр-дэмд ху - вилж. Рядом с нотами значок улыбающегося лица и надпись "мажор".

Үг. Я.Энхээ

Ая. Д.Дашням

ХИРОСИМЫН ОХИНЫ ЦААСАН ШУВУУ

Дунд зэрэг



Музыкальная запись в 3/4 такте. Под нотами текст: Ов-чинд шавал-сан он-чин о - хил Оров - дом хүс-лээр шу-вуу хий - жээ. Рядом с нотами значок грустного лица и надпись "минор".

- Хөгжмөө анхааралтай сонсоод имжний хөдөлгөөн, шинж төрхийг хөгжмөөр хэрхэн илэрхийлснийг зураглалын дагуу сонсоорой.

К.Сен-Санс



ИМЖ







- Аялгуу хаашаа чиглэсэн бэ?
- Аялгууны чиглэл яаж өөрчлөгдсөн бэ?
- Дахилтын тэмдэг :||



АРСЛАНГИЙН МАРШ

- Зохиолд арслангийн дүр дүрслэлийг хөгжмөөр хэрхэн илэрхийлснийг сонсоцгооё.
- Хөгжмийн зохиолыг зураглалын дагуу сонсоорой.



- Амьтдын наадмын үеэр жагсаал болж байна.



- Арслан архирна.



- Арслан самардана.



- Марш алхана.





ХӨГЖИМДЬЕ

Дасгал 1

- Эгшгийн цувааг хөгжимдөх явцдаа хурууны байрлалаа эргэн санацгаая.

C D E F G A B C D C

Дасгал 2

- Ноот бичлэгийг ажиглаад хоёр хоолойгоор хөгжимдөөрэй.
- Маршийн өнгө аясыг тодруулахын тулд уран илэрхийллийн ямар аргыг хэрэглэсэн байна вэ?

С.Гончигсумлаа

МАРШ

Дасгал 3

- Хэмнэлээр хөгжимдөөрэй. Юу дүрслэгдсэн бэ?
- Хөгжимдсэн хэмнэлдээ тохирох сэдэв сонгоорой. Үүний тулд хурд, хүчдэл чухал үүрэгтэй учраас тохирох хүчдэлийн тэмдгийг сонгож бичээрэй.



Дасгал 4

- Ноот бичлэгийг ажиглаад гурван баг болон хуваагдаарай.
- Ноот бичлэгт ажиглалт хийж хоолой тус бүрийн ижил болон ялгаатай талыг тодорхойлоорой.

Хоёр ба гурван хоолойгоор хөгжимдөж сурахад юуны өмнө өөр өөрийн хоолойг сайн сурна. Үүний дараа нийлж хөгжимдөх ба бусад хоолойг маш сайн анхааралтай сонсож зөөлөн тоглоно.

Дасгал 5

- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Эгшгийн цувааг гоцлоочид бишгүүрээр, цохивор хөгжимчид хэмнэлээр хамсраа хийж хөгжимдөөрэй.
- Хоёр ба гурван хоолойгоор хөгжимдөх дүрмээ санаарай.



Үг Ц.Нүүдэл

БҮЖИГЛЭЭ

Ая Ч.Алтансүх

9 САРЫН 1 (Хөгжимт хөдөлгөөн)

- “9 сарын 1” дууны хэмнэлд тохируулан бүжиглээрэй.



Хөдөлгөөнөө хийхэд
бэлтгэнэ.

Гараа хоёр тийш нь ээлжлэн түлхэлттэйгээр шиднэ.
(4 тоонд)



Хоёр гараа зэрэг баруун зүүн тийш ээлжлэн түлхэлттэйгээр шиднэ. (4 тоонд)



Хоёр тал руугаа ээлжлэн доошоо дээшээ цохилттой хөдөлгөөнийг хийж,
хөлийг өлмийгөөр товшино. (8 тоонд)



Гараа ташаандаа аван хөлөө хоёр тийш нь ээлжлэн
шиднэ. (8 тоонд)

Баруун гараа өргөөд дээшээ
үсэрснэ. (8 тоонд)



ЗААН (Хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн дүрслэлийн өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөө зөв гүйцэтгэж сураарай.



Бэлтгэх
байдал



Гараа алдлан баруун зүүн
тийш ээлжлэн хагас сууна.



Бэлтгэх байдлаас гараа урагш
сунган баруун хөлөө ардаа
тавина.



Эсрэг тал руу
давтана.



Бэлтгэх байдлаас тохойгоо өргөн
цээжээрээ хазайн баруун хөлөө өргөнө.



Эсрэг тал руу
давтана.



Өвдгөөрөө хагас суун тохойгоо дээш доош
хөдөлгөнө.



Гараа алдлан дээш
үсэрнэ.



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ

Дасгал 1

- Зургийг ажиглаад тоглож байгаа хүүхдүүдийн хөдөлгөөнийг дүрслэн аялгуу зохиоё. Үүний тулд хөдөлгөөний чиглэлийг ажиглаж ярилцаарай. Зохиосон аялгуугаа дуулж бас хөгжимдөж сонсоорой.



Дасгал 2

- “Галт тэрэг”, “Уралдаан”, “Бүүвэй” сэдвээр хэмнэлийн зохиомж хийгээрэй.
- Тухайн сэдвийн дүр зураглал, онцлогийг ярилцаарай.
- Өөрсдийн бүтээсэн хөгжмийн энгийн зэмсгээрээ хөгжимдөөрэй.
- Зургаас санаа авч төрөл бүрийн материал ашиглан чөлөөт цагаараа хөгжмийн энгийн зэмсэг бүтээгээрэй.





ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

- Багшийнхаа тайлбарыг сонсоод дүрсийг эвлүүлж өөрийгөө сориорой.
- Үүний тулд загварыг хувиран авч, тасархай зураасын дагуу хэсэгчлэн хайчилж бэлтгэнэ.

К.Сен - Санс Монгол Улсын Төрийн дуулал Бишүүр Үг Үг	Лөгтэй харгас ноот Бемоль Диез До ноот Фа ноот Лөгтө Хорвоо амгалан байг	Наймт ноот Дөхлөлтэй тэмдэг Дөрөвт ноот Наймт ноотны зогсоц Сэтгэл хөдлөл Айзаам хэмжээ Бүүвэйн дуу Хөгжмийн энгийн зэмсэг
--	--	---



ДУУЛЪЯ

Үг. Ая. С.Батболд

ШИНЭ ОН

- Дууны үгийг тод хэлж, тусгайлан тэмдэглэсэн хэсгийг анхаарч дуулаарай.

Дунд зэрэг

Зүүд ной-ронд минь үнс - сэн Зөө-лөн са-халт ө - вөө минь

Үүр шө - нийн зааг дээр Үүр-гэвч-нээ-сээ бэ - лэг өг - сөн

Ойн баав-гай Дэл-дэн туу-лай Ү-нэг чоно бүгд бай-сан

Шинэ он шинэ жил ир - лээ гээд Ца - сан о-хин на-дад хэл-сэн

Шинэ он шинэ жил ир - лээ гээд Ца-сан о-хин на-дад хэл - сэн

Шинэ он гар-лаа гар-лаа Шинэ жил ир-лээ ир - лээ

Шинэ он гар-лаа гар-лаа Шинэ жил ир-лээ ир - лээ

Шинэ он гар - лаа Шинэ жил ир - лээ



- Дууны бадаг дахилтын аялгууны шинж төрхийн ялгааг ярилцаарай.
- Доорх хоёр хэсгийн төгсгөлийг нуман холбоостой, холбоосгүй хоёр янзаар дуулаарай. Ямар ялгаатай байна вэ?

Ца - сан о-хин на-дад хэл-сэн_ Ца-сан о-хин на-дад хэл - сэн_



- “Allegretto” - Хурдавтар энэ тэмдэглэгээ ноот бичлэгийн хаана байрлах вэ?
- Юу заасан тэмдэглэгээ вэ?

Үг. О.Сундуй

Ая. М.Хатанбаатар

ЦАСАН ОХИН ХААЧСАН БЭ?

Мөч-рөө дэлгэ-сэн мөн-гөн га - цуур мө-рөн го - лын мөн-гөн дол - гио

8 цонх дүү- рэн зу - раг зур-чихаад ца-сан о - хин

13 ца-сан о - хин чи хаач - сан бэ нар хөөр-гөл унт-даг гээд

18 над - тай найз- лах - ыг хү-сээ - гүй юм уу

Самар цөмсөн мөнгөн хэрэм
Сахлаа илбэсэн мөнгөн өвөө
Цонх дүүрэн зураг зурчихаад
Цасан охин хаачсан бэ?

Навчин чихтэй мөнгөн үнэг
Намуухан ойн мөнгөн модод
Цонх дүүрэн зураг зурчихаад
Цасан охин хаачсан бэ?



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийг хэмнэлээр тогшиж ялгааг олж тогтоо.
- Хэсгүүдийн ялгааг зөв илэрхийлж дуулаарай.

Мөч - рөө дэлгэ - сэн

чи хаач - сан бэ

цонх дүү- рэн зу - раг зур- чихаад



- Хоёр хоолойгоор дуулж сурахад хамгийн гол нь бие биеэ маш анхааралтай сонсож зөөлөн дуулах хэрэгтэй.

БОЛЖМОР

Хөнгөн

Бор-хон болж-мор нойр-ноос сэр! гээд дуу - даж байна

Бор-хон болж-мор нойр-ноос сэр! гээд дуу - даж байна


Борол-дой жаа-хан най-заа ир гэж дуу - даж байна

Борол-дой жаа-хан най-заа ир гэж дуу - даж байна

Борол - дой жаа - хан най - заа ир гэж дуу - даж байна.

Борол - дой жаа - хан най - заа ир гэж дуу - даж байна.

Борол - дой жаа - хан най - заа ир гэж дуу - даж байна.



КАНОН – Аялгууг даган, хөөцөлдөж дуулах арга.



Үг. С.Гантөмөр

Ая. С.Эрдэнэ

ШИНЭ ОНЫ ХҮСЭЛ

Хурдан

Цон-хонд тогт-сон цан хүү-рэг Цог-лог дуунд минь хай-лаа- сай Дэ-вэн дэр - вэх


бүж-гэнд минь Дээв-рийн ца-санд буд - раа - сай _____ Өв-лийн өнгө нь ца-гаа - хан

ө-вөө - гийн са - хал нь ца-гаа - хан Өмс-сөн бү-хэн минь ца-гаа -

- хан Өөд-рөг сэт-гэл минь _____ ца - гаа - хан _____

Бэлгэнд баясах мишээлд минь
 Бэлийн цасан хайлаасай
 Том болсон гэдгийг минь
 Томчууд ер нь ойлгоосой

Мөчир дээр суусан болжморууд
 Миний баярыг хуваалцаарай
 Мөнх ногоон гацуур шиг
 Энх ээж минь амьдраасай



- Ижил ноотыг нумаар холбосон байна.
 - Энэ хэсгийг хэрхэн дуулснаа санаад
 тэмдгийн үүргийг ярилцаарай.

Өмс - сөн бү - хэн

- Цэгтэй хэмнэл



- “Хөх яргуй” дууны ноот бичлэгийг ажиглаарай.
- Ноотоор дуулцгаая.


ХӨХ ЯРГУЙ


Хөх яр-гуй нүд-лэх хав - раар Хөв-чин дэл-хий сэр-гэх ури - наар

Хө-хөө шу - вуу дон-го-дох дуу-наар Хүн бүх-ний бая-сах ца - гаар

Хавраар, уринаар, дуунаар гэсэн үгүүд дээр ижил ноотыг нуман холбоосоор холбосон байна. Хоёр ижил ноотыг нумаар холбосон байвал тухайн 2 ноотны хэмжээг нийлүүлж дуулдаг. Үүнийг хөгжмийн хэлэнд “лига” гэнэ.

Харин хоёр ба хэд хэдэн өөр ноотыг нумаар холбосон байвал хооронд нь амьсгаа авалгүй үргэлжлүүлэн дуулдаг. Үүнийг легато гэдгийг бид мэддэг болсон.



Ноот бичлэгт бидний мэдэхгүй  тэмдэг тавигдсан байна. Дуу, хөгжмийн зохиолын оргил болон төгсгөл хэсэгт тухайн эгшгийг хэсэг хугацаанд үргэлжлүүлэн чөлөөтэй барих тохиолдол байдаг. Үүнийг хөгжимд “фермат” буюу чөлөөт барилт гэж нэрлэдэг.



СОНСЪЁ

ХӨГЖИМ БУДАГТАЙ ЮУ?

Хүмүүсийн яриа маш олон янзын өнгө аястай. Гуйх, хүсэх, аргадах, тушаах, асуух, хариулах бүгд өөр өөр өнгө аяс өөр өөр хүчтэй. Үүнтэй адил хөгжмийн зохиол чанга эсвэл зөөлөн эгшиглэдэг, мөн нэгээс нөгөө рүү огцом эсвэл аажмаар шилждэг.

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Юу дүрслэгдэж байна вэ?
- Галт тэрэгний хөдөлгөөнийг чухам юунаас олж мэдэрч байна вэ?
- Галт тэрэгний зогсолтгүй урагшаа тэмүүлэх жигд хэмнэл, хурд, хүч, ямар сэтгэлийн хөдөлгөөнийг төрүүлж байна вэ?
- Дараах хэмнэлээр хамсран хөгжимдөөрэй.
- Галт тэрэгний алсаас ойртон ирэх, дэргэдүүр өнгөрөх, алслан одох дүр зургийг хэрхэн илэрхийлэх вэ?




- Доорх зургийн чиглэл, хэмжээ, өнгөний өөрчлөлт юу илэрхийлж байна вэ?
- Морьдын төвөргөөн ойртох, дэргэдүүр өнгөрөх, холдон одох, мөн дэлгэрэн цэцэглэх, уусан алга болох үзэгдлийг дараах зураглалтай холбон тайлбарлаарай. Үүнийг туршилтаар нотлоё.
- Цайвар шар, шар, тод шар, улбар шар гэх мэт олон янзын өнгийн дагнаас бүхий дөрвөлжин картуудыг хийж бэлтгээрэй.
- Л.Мөрдорж “Ган зам” зохиолыг сонсоод, өнгийн картуудаа аялгууны чангаралт, хүчний өөрчлөлтөд тохируулж эгнүүлэн тавина уу.






Дууг чанга дуулах уу, зөөлөн дуулах уу гэдэг дурын хэрэг биш юм. Харин тухайн дуу, хөгжмийн зохиол юун тухай өгүүлж байна вэ? гэдгээс шалтгаалдаг. Багш, найз нөхөд, гэр бүлийнхээ гишүүдийн жирийн яриаг сонсоод үз. Ярианы өнгө аяс нь ярьж байгаа хүний сэтгэл хөдлөлөөр нэг үе чангарч, нэг үе зөөлөрч байгаа биз. Хөгжим ч бас түүнтэй адилхан.

Эгшиглэх хүчний энэ өөрчлөлтийг хөгжимд хүчдэл гэнэ. Иймээс хүчдэл нь утга санаа илэрхийлэх хөгжмийн хэлний нэг чухал хэрэглүүр юм. Хөгжим хэр зэрэг аяар, чанга дуугарахыг хүчдэлийн тэмдгүүд заана. Хүчдэлийг итали үгээр нэрлэж эхний үсгээр нь тэмдэглэдэг.



- Зургийг ажиглаад авиа эгшгийг зөөлнөөс чанга руу, чангаас аажмаар зөөлрүүлж дуулаарай.
- Өгөгдлийг бөмбөрөөр тоглож илэрхийлээрэй.




- Дараах хүчдэлийн тэмдгүүдийг ажиглаад, хүчний өөрчлөлт хаашаа чиглэснийг дэвтэртээ зурж тэмдэглээрэй.

<i>p</i>	<i>f</i>	
<i>f</i>	<i>mf</i>	
<i>mf</i>	<i>ff</i>	
<i>mp</i>	<i>pp</i>	



ЭЛЬФҮҮДИЙН БҮЖИГ

- Үлгэрт гардаг эльф хэмээх сайхан сэтгэлт ойн бяцхан хүмүүсийн тухай өгүүлэх хөгжмийг зураглалын дагуу сонсоцгооё.
- Аялгууны шинж төрх хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлоорой. Яагаад?
- Өнгөний өөрчлөлт юу илэрхийлж байна вэ?
- Эгшиглэх хүчний өөрчлөлт юутай холбоотой вэ?



Эльфүүд хөгжилдөн бүжиглэнэ. Гэнэт доод өнгийн эгшгүүд дуугарч бүжиг түр зогсох нь тэднийг хэн нэгэн айлгав уу гэлтэй. Гэвч эльфүүд тайвшран дахин эргэлдэн бүжсээр нисэн одно.



Стаккато буюу огцом тоглогдох арга барилаар эльфүүдийн бүжгийн ямар хөдөлгөөнүүдийг дүрсэлж байна вэ?

Легато буюу эгшгүүдийг холбон тоглох арга барилаар илэрхийлэгдэх дээш өгссөн наймт ноотууд эргэлдэн нисэх мэт хөдөлгөөнийг дүрсэлжээ.




- Зурагт хэдэн ялгаа байна вэ?
- Үүнтэй адил ноот бичлэгийг ажиглаад ялгааг олцгооё.
- Анхаарлаа төвлөрүүлж аялгууны ялгааг олж сонсоорой.
- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүд хоорондоо ямар ялгаатай байна вэ?
- Хэмнэлээр тогшоорой. Юугаараа адил байна вэ?




Ф.Шопен

ПРЕЛЮДИ



ХӨГЖМИЙН ХУРД

Хөгжмийн зохиолын утга санаа, үйл явдал хэрхэн өрнөж байгаагаас шалтгаалан удаан, түргэн янз бүр дуулж хөгжимддөг. Дуулах, хөгжимдөх удаан түргэний харьцааг тодорхойлсон нэр томъёог хурд буюу темп гэнэ. Темп нь хугацаа гэсэн утгатай латин үг. Хөгжмийн хэлэнд хурдыг ихэвчлэн итали үгээр тэмдэглэж зохиолын эхэнд бичдэг. Темпийг үндсэн гурван хэсэгт хуваана.





ӨРГӨӨНИЙ БАЯР НААДАМ

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Аранзал зээрд шүлгээс ямар хурдыг мэдэрч байна вэ?
- Шүлгийн аль хэсгийг хөгжмөөр дүрсэлснийг олж тэмдэглээрэй.
- Хөгжмийн зохиолын хурдыг тодорхойлцгооё.



Ж.Дашдондог

АРАНЗАЛ ЗЭЭРД

Аранзал зээрд мориороо
Алхуулан шогшууллаа
Шогшуулснаа хатирууллаа
Хатируулснаа ергүүллээ
Ергүүлснээ цогиуллаа
Цогиулснаа давхиуллаа
Талаар талаар
Ташуур өгөн довтолгов
Замаар замаар
Тоос босгон хурдлав.

Хатан дэлхийг
Дөрвөн туурай
Дөрвөн туурай бөмбөрдөнө
Хайрга чулуу
Арван зүгтээ
Арван зүгтээ цацагдана
Хөрст дэлхий

Хөлийн дор
Хөлийн дор жирэлзэнэ
Хөтөл гүвээ
Холын холд
Холын холд торолзоно.
Сумын бараа
Тодорлоо тодорлоо
Сургуулийн байшин
Ойртлоо ойртлоо

Аранзал зээрд мориныхоо
Амыг татан цогиуллаа
Цогиулснаа ергүүллээ
Ергүүлснээ хатирууллаа
Хатируулснаа шогшууллаа
Шогшуулснаа алхууллаа.

- Шүлгийн эхлэл хэсгийн дүрслэлд тохирох хөгжмийн хурдыг тодорхойлоорой.

- а. Хурдан
- б. Аажим хурдсах
- в. Удаавтар

- Энэ хэсгийн дүрслэлд тохирох хүчийг тодорхойлоорой.

а. *ff* б. *mp* в. *f*



- Шүлгийн төгсгөл хэсгийн хурд, хүчийг тодорхойл.



УРАН ИЛЭРХИЙЛЛИЙН АРГУУД

Туршилт.

- Шулуун шугамыг хуруугаараа дагуулан зааж нэг өнгөн дээр “а” авиагаар дуулаарай. Шугамыг дуустал дунд нь таслалгүйгээр нэг амьсгаагаар, дуулна.

аа

Үүнтэй адил хөгжмийн эгшгүүдийг өөр хооронд нь салгалгүй үргэлжлүүлэн дуулж хөгжимдөхийг заасан тэмдгийг легато гэдэг.

- Нумаар холбосон ноотуудыг салгалгүй үргэлжлүүлэн (легато) дуулаарай.

Хээ-рийн амь-тад-тай нө -хөр-лөс гэвч Хэ -лийг нь даанч ойл-гох - гүй юм

- Цэг бүрийг хуруугаар хатгах мэт зааж огцом тасалдангуй дуулаарай.

а! а! а! а! а!

Хөгжмийн эгшгүүдийг огцом тасалдангуй дуулж хөгжимдөхийг хөгжмийн хэлэнд стаккато гэдэг. Ноотны дээр ба доор цэгээр тэмдэглэнэ.

- Стаккатог хэрхэн хөгжимдөж байгааг анхааралтай сонсоод ноот бичлэгийг ажиглаарай.



С.Гончигсумлаа.

МАРШ

Хөгжмийн эгшгүүдийг тасралтгүй үргэлжлүүлэн, эсвэл тус тусад нь салангид, мөн огцом тасалдангуй дуулах нь хөгжмийн зохиолын утга агуулга, дүр дүрслэлийг улам тодотгож өгөх арга юм.



ХӨГЖИМДЬЕ

Дасгал 1

- Дасгалыг хөгжимдөхдөө хурууны байрлалыг анхаараарай.
- Эгшгийн үсрэлттэй хэсгийг анхаарч хөгжимдөөрэй.




- Дээрх дасгалын тусгайлан тэмдэглэсэн хэсэгт хурууны байрлалыг олон удаа давтаарай.

Дасгал 2




- Хоёр хоолойгоор хөгжимдөхийн өмнө доорх хэмнэлийн дасгалыг гүйцэтгээрэй.
- Зогсыг зөв мэдэрч хөгжимдөхөд ноотоо харж тоолох маш чухал.





Дасгал 3

- Аялгууг хөгжимдөөд ямар дуу болохыг нэрлээрэй.
- Тусгайлан тэмдэглэсэн хэсгийг анхааралтай хөгжимдөөрэй.




Дунд зэрэг



Дасгал 4





- Хоёр хоолойгоор хөгжимдөөрэй.



Аялгуунд хэмнэлийн хамсраа хийхдээ гоцлоочийг анхааралтай сонсож, зөөлөн тоглоно. Хэмжээгээ зөв авч дотроо тоолж хөгжимдөнө.

Дасгал 5

- Хоёр хоолойгоор хөгжимдөөрэй.





БҮЖИГЛЭЭ

ДӨРВӨД БИЕЛГЭЭ

- Морин хуурын татлагад тохируулан монголын уламжлалт бий биелгээний хөдөлгөөнийг хийж сураарай.



Арьс элдэж биелнэ
Сур элдэж биелнэ.



Ноос савж биелнэ.



Гурил шигшиж биелнэ.



ХАМТДАА БҮЖИГЛЭЭ (тойрон бүжиг)

- Ая.С.Батболд “Анд нөхөдтэйгөө цуг явахад” дууны аялгууны хэмнэлд тохируулан тойрон бүжиг хийцгээе.
- Хөдөлгөөнийг тус тусдаа хийж сураад ангиараа хамтарч бүжиглээрэй.



Хоёр тийш
ээлжлэн алхалт
хийнэ. (8 тоонд)



Зүүн хөлөө баруун урагш, баруун
хөлөө зүүн урагш нь өргөж ээлжлэн
өсгийгөөр нь тавина.



Зүүн хөлөө баруун
арагш нь өлмийгөөр
тавина.



Баруун хөлөө зүүн
арагш нь өлмийгөөр
тавина.



Хөлөө ээлжлэн солбиж урагш шидэх
хөдөлгөөнийг хийнэ. (8 тоонд)



Урагшаа 4 тоонд,
арагшаа 4 тоонд
алхана.

Хөдөлгөөнөө бие даан хийж сураад, хамтдаа тойрон бүжиглээрэй.



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ

Дасгал 1

- Дараах хэмнэлээр юуг дүрслэн илэрхийлэхэд (амьтан, галт тэрэг...) тохиромжтойг ярилцаарай.




Дасгал 2

- Өгөгдсөн дуу, шүлгэнд хүчдэлийн ямар тэмдгүүд тохирох вэ?
- “Цас” сэдвээр 4/4 хэмжээнд аялгуу зохиогоорой. Чиний зохиосон аялгууг хүчдэлийн тэмдгүүд тодотгох болно.

 <p>Үү-рийн шу-вуу-дын жир-гээ шинэ-хэн</p>	<i>p</i>	 <p>Ши-нийг хайх эр-лийн өг-лөө</p>	?
<p>Хатан дэлхийг Дөрвөн туурай Дөрвөн туурай бөмбөрдөнө Хайрга чулуу Арван зүгтээ Арван зүгтээ цацагдана.</p>	<i>f</i>	<p>Ухаан бодлыг уяруулсан Унаган төрөлх нутаг Уран долгио уралдуулсан Урсгал дөлгөөн Хэрлэн гол</p>	?

Дасгал 3

- Хүчдэлийн тэмдгүүдийг нэрлээрэй.
- Амьтдын дуугаралтын хүчийг ярилцаад тохирох хүчдэлийн тэмдгийг бичээрэй.
- Хүчний өөрчлөлтийг өгсөх, уруудах дараалалд оруулж бичээрэй.



Дасгал 4

- Чиний дуулах дууны хурдан, удаан нь юунаас шалтгаалах вэ? Зөв хариултыг сонгож дэвтэртээ бичээрэй.
 - зохиолын утга санаанаас
 - хөгжимчнөөс
 - дуучны хоолойноос



Дасгал 5

- Төгөлдөр хуурын даруул дээр тэмдэглэсэн ноотуудыг ашиглан 4/4 айзам хэмжээнд аялгуу зохиоцгооё. Аялгууны хэмнэлдээ зогсцыг ашиглаарай.
- Өөрийн зохиосон аялгуугаа хөгжимдөөрэй.


а



б



в



Дасгал 6

- Голын хүснэгтэд өгөгдсөн үгсийг уншаад, хоорондын уялдаа холбоог олж тогтоогоорой.
- Олсон хувилбараа дэвтэртээ нар зөв тойруулан бичээд тайлбарлаарай.





ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

- Багшийн хөгжимдөхийг сонсоод хүчдэлийг тодорхойлоорой.
- Зохиолын хурдыг тодорхойлоорой.

1. а. б.

2. а. б.

- Багшийн хөгжимдөхийг сонсоод ноот бичлэгийг ажиглаарай. Аль хэсгийг хөгжимдөж байна вэ?

а.

б.

- Хурдац болон хүчдэлийг заасан хөгжмийн нэр томъёонуудыг уншаад ангилаарай.

- | | | | |
|------------|---------------|-----------|---------------|
| 1. аллегро | 3. умерато | 5. адажио | 7. меццопиано |
| 2. форте | 4. диминуэндо | 6. престо | 8. крешендо |

- Эгшгийн эрэмбийг өгөгдсөн хөгт өгсөх, уруудах чиглэлд дараалуулан бичээд дуулаарай. G-dur, e-moll
- Өгсөх, уруудах чиглэлд хүчдэлийн ямар тэмдэг тохирох вэ?
- Аллегро, адажио, умерато хурдны ялгааг тодорхойлоорой.
- График дүрслэлд харгалзах хурдыг олж тогтоогоод тайлбарлаарай.



- Хөгжмийн зохиолч П.И.Чайковскийн “Неаполитан бүжиг” зохиолыг анхааралтай сонсоод дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

а. Ямар хөгжмийн зэмсэг вэ? Дэвтэртээ бичээд \sqrt тэмдэглэгээ хийгээрэй.

- флейт труба төгөлдөр хуур хийл

б. Эгшиглэх хүч ямар байсан бэ?

- f* *P*

в. Аялгууны шинж төрхийг тодорхойлоорой.

- гялалзсан эрчимтэй удаан уянгалаг түгшүүртэй

г. Хөгжмийн зохиолоос ямар өнгийг мэдэрч байна вэ?



ДУУЛЪЯ

- Дараах хэмнэлээр эгшгийн цувааг дуулаарай.



- Ноотоор дуулцгаая.
- Дууны утга агуулгыг ярилцаад ямар хурдаар дуулахад тохиромжтой болохыг тодорхойлоорой.

Үг. Д.Нацагдорж

Ая. Г.Эрдэнэбаатар

ХЭНЗ ХУРГА

Хурдавтар

Ми-ний хэнз хур-га маг-най хал-зан зур-вас - тай
 Мян-ган хони - ны дун-даас би хар - магц тань - даг
 мярс мярс майл- саар на - майг чиг-лэ - сээр ир - дэг

Дун цагаан үстэй
 Дуран хар нүдтэй
 Түмэн хонины дундаас
 Түүнээс хөөрхөн амьтангүй
 Төрсөн хотон дотроо
 Тэр бид хоёр тоглодог

Өвдгөө сөгдөж байгаад
 Өөрийнхөө ээжийг хөхдөг
 Өвөр дээр минь гараад
 Өхөөрдмөөр эрхэлдэг
 Нааш цааш дэгдэн
 Малчин эзнээ баясгадаг



Allegretto – хурдавтар

Миний хэнз хурга дууг дээрх хурдаар дуулна.
 Дуулах хөгжимдөх хурд нь зохиолын утга агуулгаас шалтгаалдаг.



- Дараах хэмнэлээр эгшгийн цувааг дуулаарай.



Үг. Х.Найдан

Ая. Л.Даваахүү

НЭГ АНГИЙНХАН

Хурдан

Ma-nay an-giyn o - hid xov-guud mash sai - han yu - erx - deg yom daa тий - мээ

бүг-дээ - рээ ү - нэнч найз нар шүү нэ - гэн э - хээс тө - рөө

гүй ч нэг ан - гийн ол - ноо хө нэ - гэн гэр - тээ тор - нio

гүй ч нэ - гэн ан - гийн нөх - дөө хө

Манай ангийн багш маань биднийг
Маш сайн сураарай гэдэг юм даа
Тиймээ бүгдээрээ онц сайн сурцгаана
Нэгэн эхээс төрөөгүй ч
Нэг ангийн олноо хө
Нэгэн гэртээ торниогүй ч
Нэгэн ангийн нөхдөө хө



Дууны тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийг анхааралтай сонсоод хэмнэлээр алга ташаарай. Үгийн хуваарилалт, хэмнэлийг зөв илэрхийлж дуулаарай.



Allegro – Хурдан

Нэг ангийнхан дууг дээрх хурдаар дуулна. Хөгжилтэй, цовоо сэргэлэн дуулж утга агуулгыг илэрхийлнэ.

маш сай - хан ү - ерх - дэг

тө - рөө гүй



- Хэмнэлийн зураглалаар эгшгийн цувааг дуулаарай.



- Багшийн дуулж хөгжимдөхийг сонсоод дагаад дуулаарай.
- Дуулах хурдыг тодорхойлоорой.

Үг. С.Дашдооров

Ая. З.Хангал

ЦЭЦЭГ ЮМ УУ БИ

Баясгалантай

Эж та э - нийг ха - раа_ Эж-дээ бая-раар бэ-лэг-лэх гээд

5 Энх - рийлж ур - гуул-сан_ Эн-гүй сай-хан ал - тан зул_ Дэл-гэр

10 цэ-цэг минь_ Дэл-хий дүү-рэн ур - гаа - рай_ анхи-лам_ цэ-цэг минь_

15 Ал -тан на - ранд шүр - гээ - рэй_ ля ля

18

Намайг та цэцэг гэдэг
Наадан тоглох болгондоо
Нандин цэцэг гэдэг
Нээрээ би цэцэг юм уу

Нээрээ би цэцэг юм бол
Энийгээ ч өөрийгөө ч
Тандаа бэлэглэе
Та ч бас цэцэг юм шүү



Дэл-гэр__



бэ-лэг-лэх гээд





СОНСЪЁ

И.Брамс


БҮҮВЭЙН ДУУ

- Хөгжмөө анхааралтай сонсоод ноотоор дагаад аялаарай.
- Аялгууны шинж төрх ямар мэдрэмжийг төрүүлж байна вэ?
- Дуулаад бадаг дахилтыг тодорхойлоорой.
- Дууны утга агуулгад тохирох хурд, хүчийг олж тогтоогоорой.

Удаавгар

Ам-га - лан тай - ван Нойр-сох цаг бол-жээ үр-минь Ам-тат зүү-дээ зүүд-
 7 - лээд Тай-ван нойрс-доо үр минь Шө-нийн са - ран ав - хай Цон - хоор
 12 ми-шээн шир- тэнэ Салхи-ны зөө - лөн сэв - шээ Хүүд минь дуу__ ая - л - на

- Зурган дүрслэлд хөгжмийн зохиол хэдэн хэсэгтэй байна вэ?



А
бадаг

Амгалан тайван
Нойрсох цаг болжээ үр минь
Амтат зүүдээ зүүдлээд
Тайван нойрс доо үр минь



В
дахилт

Шөнийн саран авхай
Цонхоор мишээн ширтэнэ
Салхины зөөлөн сэвшээ
Хүүд минь дуу аялна

Бүүвэйн дууны бүтэц хэлбэр

А + Б
бадаг дахилт




УДИРТГАЛ ХӨГЖИМ (Вилгельм Телль дуурийн удиртгал)

- Хөгжмөө анхааралтай сонсоод ажиглаарай.
- Уриа дуудлагыг ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдөж байна вэ?
- Удиртгал хөгжим хэдэн хэсгээс бүтэж байна вэ?
- Хэсгүүд өөр хоорондоо ямар ялгаатай байгааг сонсоод тодорхойлоорой.



Гурван хэсэгт хэлбэрт ихэвчлэн эхний хэсгийг төгсгөлд нь давтах нь (АБА) элбэг тохиолддог.

- Хөгжмөө сонсоод өгөгдсөн хэмнэл зохиолын аль хэсэгт байгааг тодорхойлоорой.



С.Гончигсумлаа



БОДОЛ

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдөж байна вэ?
- Хөгжимдөх хурд солигдсон уу? Зөв хувилбарыг сонгоорой.
 - а. Удаавтар – хурдан – удаавтар
 - б. Хурдан
 - в. Удаан – хурдан

а. Гуниглуун



б. Хөгжилтэй

- Зохиол хэдэн хэсгээс бүтэж байна вэ?





Ж. Чулуун

МОНГОЛ АРДЫН ДУУНЫ ХУВИЛБАР АЯЗ

- Зургийг ажиглаад хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Зохиол хэдэн хэсэгтэй байна вэ?
- Хэсэг тус бүрийн хурдыг (темп) тодорхойлоорой.
- А, Б хэсгүүд хоорондоо ямар ялгаатай байна вэ?
- Эхний ба сүүлийн хэсэг хоорондоо ялгаатай юу?

<p style="text-align: right;">А</p>  <p>Хийл хөгжим доод регистрт “Цомбон туурайт хүрэн” хэмээх монгол ардын уртын дууны талбиун сайхан аялгууг намуухан эгшиглүүлэн гоцолно. Улмаар аялгуу улам бүр уян тансаг болж хийл хөгжмийн нарийн дээд эгшигт шилжин хоёр дахь удаагаа давтана.</p>	<p style="text-align: right;">Б</p>  <p>Хийл хөгжмөөр эгшиглэх удаан аялгууг найрал хөгжим залган авч хөнгөн цоглог аялгуунд шилжинэ. Энэ бол зохиолын хоёр дахь хэсэг. Энэ ангид Цомбон туурайт хүрэн-ээс эрс ялгаатай хөнгөн, цоглог аялгуу дуурсана. Энэ бол “Хоёр сэтгэл” хэмээх монгол ардын богино дуу юм.</p>	<p style="text-align: right;">А</p>  <p>Харин зохиолын гурав дахь хэсэгт эхний ангийн “Цомбон туурайт хүрэн” уртын дууны аялгуу хийл хөгжмийн нарийн дээд эгшгээр хэдэнтээ давтагдан зохиол төгсөнө. Зохиолын эхний ба сүүлийн хэсэг нь сэдвийн хувьд ижил учраас гурав дахь хэсгийг нь дахилт (реприз) гэдэг.</p>
--	---	---

Хөгжмийн зохиолч Ж.Чулууны хийл, найрал хөгжимд зориулсан монгол ардын хоёр дууны сэдэвт хувилбар аяз нь ардын дуу хөгжмийн уламжлалыг хадгалсан бүтээл юм.

1975 онд болсон Азийн хөгжмийн наадмаас Ж.Чулууны “Ардын хоёр дууны сэдэвт хувилбар аяз”-ыг Азийн орнуудын радиогоор заавал нэвтрүүлж байх хөгжмийн бүтээлийн санд авсан юм.

“Ардын хоёр дууны сэдэвт хувилбар аяз” нь сонсогчийн сэтгэлийг өөрийн эрхгүй догдлуулдаг. Энэ бол хүний сэтгэлийн гуниг баяслыг яруу тод дүрсэлсэн бүтээл юм.



ХӨГЖМИЙН ЭНГИЙН ХЭЛБЭРҮҮД

- Дараах дуу болон хөгжмийн зохиолыг дуулж, сонсоод бүтэц хэсгүүдийг ажиглаарай.

Нэг хэсэгт хэлбэр



- Л.Галмандах “Тоглоомууд минь ядраа байлгүй”
- Ц.Намсрайжав “Халуун элгэн нутаг”

Хоёр хэсэгт, бадагчилсан хэлбэр (бадаг + дахилт)



- И.Брамс “Бүүвэйн дуу”
- Ц.Нацагдорж “Балчир насны нөхөр”

Гурван хэсэгт хэлбэр




- Ж.Россини “Вилгельм Телль” дуурийн удиртгал хөгжим
- Э.Чойдог “Жалам хар”
- Б.Дамдинсүрэн “Хэнтийн өндөр ууланд”

Хувилбарт хэлбэр



- Ж.Чулуун “Ардын хоёр дууны хувилбар аяз”
- Клара Шуман “Вариац”

Тойрог хэлбэр (Рондо)



- Л.В.Бетховен VIII сонат III анги
- В.А.Моцарт “Рондо”



ХӨГЖИМДЬЕ

Торгууд ардын дуу

ТООХУУ НЭГЭН ХОС

Дунд зэрэг

TWINKLE TWINKLE LITTLE STAR

- Ноот бичлэгийг ажиглаарай.
- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Аялгуу давтагдсан уу?
- Аялгууны давталтууд ялгаатай юу? Чухам юу өөрчлөгдсөн бэ?

A

twin kle twin - kle lit - tle star How I won - der what you are

Up a - bove the world so high like a dia - mond in the sky

A-1

A-2

Б.Цогоо

ШӨНӨ

Удаан




- Ноот бичлэгийг ажиглаарай. Аялгуунд давталттай хэсгүүд байна уу? Тэмдэглээрэй.

ТООРОЙН ЦАГААН ЭЛС

Баяд ардын бүүвэйн дуу

ЭХИЙН ДУУ

Си бемоль эгшиг



Си бемоль эгшиг – В үсгэн тэмдэглэгээ



БҮЖИГЛЭ

УРАЛДААН (Хөгжимт хөдөлгөөн)

- Үг. Ц.Нүүдэл, Ая. Ч.Алтансүх “Соён хээр” дууны аялгууны хэмнэлд тохируулан морь уралдаж буй хүүхдүүдийг дүрсэлж бүжиглээрэй.



Соён хээр үрээ минь



Саадаг нумлах газраар



Салхи исгэрэн шуугиулсаар



Суран жолоо өргүүлсээр



Гийнгоо гийнгоо
Гийнгоо гийнгоо



ТОГОРУУНЫ БҮЖИГ (хөгжимт хөдөлгөөн)

- А.Аренский “Тогоруу” хөгжмийн аялгууны хэмнэлд тохируулан тогорууны хөдөлгөөнийг дуурайн бүжиглээрэй.



Тогоруу үр тариа тоншин тонголзох хөдөлгөөн
(Хүзүүгээ урагш хойш сунган өвдгөө өндөр өргөн явна).



Далавчаа дэвэн хөнгөн гүйх хөдөлгөөн
(хоёр гараа дээш доош хөдөлгөн өлмий
дээрээ хөнгөн эргэлдэнэ).

Тогорууны нааш цааш холхих
хөдөлгөөн (хоёр гараа ардаа нугалан
өвдгөө өндөр өргөн хөнгөн гүйнэ).



ТАЯГТ (хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн дүрслэлийн өөрчлөлтийг мэдэрч, хөдөлгөөнөө зохицуулаарай.
- Аялгуугаа сонсоод хөгжилтэй бүжиглэцгээе.



Үндсэн аялгуу эхлэхэд бүгд тойргоор алхана. Дараа нь баруун зүүн тийш дорoo эргэнэ.

Аялгуу өөрчлөгдөхөд 1-р хүүхэд хөдөлгөөн зохиож хийнэ.

1-р хүүхдийн хийсэн хөдөлгөөнийг бүх хүүхэд дагаж гүйцэтгэнэ.

Үндсэн аялгуу дахин эгшиглэхэд бүгд жигд алхаагаар тойрон явна.

Аялгуу дахин солигдоход 2-р хүүхэд өөр хөдөлгөөн зохиож хийнэ.

Бусад хүүхдүүд 1, 2-р хүүхдийн хийсэн хөдөлгөөнийг давтаж хийнэ.

Энэ зааврын дагуу уг хөгжимт хөдөлгөөнийг үргэлжлүүлэн тоглоно.



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ

Дасгал 1

- Дараах хурдыг илэрхийлсэн хөгжмийн зохиомж хийцгээе.
- Зохиомж хийхдээ амьтдын онцлог шинжийг анхаараарай.

Largo - удаан

Andante - яаралгүй тайван


Allegro - хурдан

Allegretto - хурдавтар

Presto - маш хурдан

Moderato - намжуухан

Andantino - удаавтар



Дасгал 2

- Эгшгийн тоон илэрхийллийг анхааралтай ажиглаарай.
- Өгөгдсөн эгшгээс хөдөлгөөний чиглэлийн дагуу аялгууны хэсгийг бүтээцгээе.
- Зохиосон аялгуугаа ноотоор бичээд дуулаарай





Дасгал 3

- Өгөгдсөн айзамд ямар хэмжээтэй ноот хэд байх вэ?

$$\frac{3}{4} = \boxed{3} \quad \boxed{\text{J}} \quad \frac{3}{8} = \boxed{} \quad \boxed{}$$

$$\frac{2}{4} = \boxed{} \quad \boxed{} \quad \frac{4}{4} = \boxed{} \quad \boxed{}$$

$$\frac{6}{8} = \boxed{} \quad \boxed{} \quad \frac{6}{4} = \boxed{} \quad \boxed{}$$

Дасгал 4

- Уншаад тохирох тэмдэгийг олж үүргийг ярилцаарай.

Чангавтар



Эгшиг уруудах



Зөөлөн



Төгсгөл



Эгшиг өгсөх хөдөлгөөн



Дахих тэмдэг



Чанга



Дасгал 5

- Ноотоор дуулаад зогсоцтой хэсэгт хөгжимт хөдөлгөөн эсвэл хэмнэлийн сонирхолтой хувилбар зохиогоорой.






Дасгал 6

- Зургийг ажиглаарай. Зураг дээрх хөдөлгөөнүүдийн онцлог нь юу вэ?
- Өгөгдсөн тэмдэглэгээг ашиглан “а” авиагаар дуулаад үзээрэй. Ямар шинж төрхүүдийг илэрхийлж болохыг ярилцаарай.



Дасгал 7

- Самбарын үзэг, өнгийн тосон харандааны хуванцар хөндий гол...гэх мэт гарын доорх хэрэглэгдэхүүнийг ашиглан түүнийгээ өнгөт нарийн хуулгаар гоёж бүрээд цохиур хөгжмийн зэмсэг хийж бүтээгээрэй.
- Хийсэн зэмсгээрээ хөгжмийн хамсраа хийж хөгжимдөөрэй.





ДУУЛЪЯ

- Ноотоор дуулцгаая. Хурдыг тодорхойлоорой.
- Дахилтаас хоёр хоолойгоор дуулна. Хоолой тус бүрийг сайн сурсны дараа нэгдэж дуулаарай.

Үг. Л.Соронзонболд

Ая. С.Батболд

ГОВИЙН ӨГЛӨӨ

7

13

18

Тэ-нүүн го-вийн өг-лөө-ний на-ран Тэн-гэ-рийг сү-лэн
сү-лэн гэ-рэл-түүл-сээр Тэр-тээх уу-ланд туна-ран гий-лээ
Өг-лөө-ний нар манд-лаа Өө-дөө өө-дөө хөөр-лөө
Өг-лөө-ний нар манд-лаа Өө-дөө өө-дөө хөөр-лөө лөө

Ганган говийн өглөөний наран
Газраас урган урган өндийсээр
Галтай туяа нь над дээр туслаа

Уудам говийн өглөөний наран
Уянга дуугаа нэмэн нэмсээр
Урам хайрлан ажилд дуудлаа

Өглөөний нар мандлаа
Өөдөө өөдөө хөөрлөө



- Тусгайлан тэмдэглэсэн хэсгүүдийн үгийн хуваарилалтыг анхаарч дуулаарай.

сү-лэн гэ-рэл түүл сээр тэр тээх

- Дараах хэсэгт өөдөө гэсэн үгийг хоёр өөр хэмнэлээр дуулж байгааг анхаарч сонсоорой.

Өө-дөө өө-дөө хөөр-лөө



ТАЙГЫН ОРОЙ

4

Тож - той тай - гын Тож - той тай - гын о - рой - гоор
 Тоо - дон ца - гаан Тоо - дон ца - гаан дээ - лийнх нь
 То - рол - зуу - лаад то - рол - зуу - лаад дав - лаа - даа
 Хор - мой нь хий - сээд хор - мой нь хий - сээд дав - лаа - даа

Жангас тайгын жангас тайгын оройгоор
 Торолзуулаад торолзуулаад давлаа даа
 Жаахан цагаан жаахан цагаан дээлийнх нь
 Хормой нь хийсээд хормой нь хийсээд давлаа даа

- Эгшгийн цувааг хоёр хоолойгоор дуулъя.

Охид

Хөвгүүд

5

То - рол - зуу - лаад то - рол - зуу - лаад дав - лаа - даа
 То - рол - зуу - лаад то - рол - зуу - лаад дав - лаа - даа

- Өгөгдсөн аялгууны зогсцыг зөв илэрхийлж дуулаарай.

То - рол - зуу - лаад то - рол - зуу - лаад дав - лаа - даа



АРАВ ДАХЬ ЭРДЭНЭ

Цовоо

Үсэг зааж нүдийг нээсэн
 Үг холбож ухаан тэлсэн
 Үлгэрт шингэсэн үнэн хүчтэн
 Үлэмжийн ачтан миний л багш та

Ерөөл хүслийг бэлгэдсэн
 Есөн эрдэнэ байдаг болохоор
 Ардын багш таныг нэмээд
 Арав дахь эрдэнээ болгохсон




- Хэмнэлээр тогшоорой.
- Дараах хэмнэл зохиолын туршид давтагдаж байгааг ноот бичлэгээс ажиглаарай.



- Ноотоор дуулаарай. Дуулахдаа хэмнэлийн хамсраа хийж хөгжимдөөрэй.



- Ноот бичлэгийг анхааралтай ажиглаарай. Хэмнэлээр алга ташаарай.
- Дууны аль хэсэгт энэ хэмнэл тохирохыг олоорой.



Үг. Ж.Дашдондог

Ая. Г.Пүрэвдорж

ТҮҮДЭГ ГАЛ

Баясгалантай

А- гуй гэр - тээ аж төрөх- дөө Анх-ны хүн сүр-гийн А-сааж олж нээ-сэн

9 Түү-дэг га - лын хэ-сэг шүү Түүнд цу-чил нэ-мээ-рэй Түл-сэн га-лаа өр -дөө - рэй

17 Гал гал түү-дэг гал Ас ас бад-ран ас Га-лын дөл өө - дөө

25 Гал гал түү-дэг гал Ас ас бад-ран ас Га-лын дөл дээ - шээ

Тужийн нарсанд тулалдаж явахдаа
Ардын журамт цэргийн асаан тойрч суусан
Түүдэг галын очис шүү
Түүнд цучил нэмээрэй
Түлсэн галаа өрдөөрэй.

Алсын одонд айлчлан хүрэхдээ
Анд найз бидний асаан тойрч сууцгаах
Түүдэг галын очис шүү
Түүнд цучил нэмээрэй
Түлсэн галаа өрдөөрэй.

аж төрөх- дөө

Гал гал түү-дэг гал Ас ас бад-ран ас




СОНСЪЁ

М. И.Глинка

РУСЛАН ЛЮДМИЛА ХОЁР (Удиртгал)


- Хөгжмөө зураглалын дагуу анхааралтай сонсоорой.
- Аялгууны шинж төрхийг дараах график дүрслэлээс олж тэмдэглээрэй.
- Сонгосон дүрслэлээ хөгжмийн өнгө будаг, хүч, хурдтай холбон тайлбарлаарай.
- Хөгжмийн зохиолыг сонсоод ямар сэтгэгдэл төрсөн бэ?
- Зохиолыг ямар өнгө будгаар төсөөлж байна вэ? (гялалзсан, хурц тод, бүрхэг бүүдгэр, хүйтэн, гэрэл цацарсан, алтарсан, саарал, халуун дулаан...гэх мэт)



Сайн сайхан, баатарлаг ялалтын аялгуу



Уянгын тэмүүлэлтэй аялгуу



Энэхүү удиртгал хөгжимд саад бэрхшээл бүхнийг сайн сайхан үйлсээр даван туулж ялалтанд хүрдэг гэсэн санааг илэрхийлжээ. Иймээс хөгжим бүхэлдээ хүчирхэг, цогтой тэмүүллээр дүүрэн эгшиглэдэг.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Хөгжмөөс ямар дүрслэлийг бүтээсэн бэ? Тайлбарлаарай.
- Сонссон зохиолдоо нэр өгөөрэй.
- Зургийг ажиглаад аялгууны шинж төрхөд тохирохыг сонгоод ярилцаарай.



1. Л.В.Бетховен V симфонийн хэсгээс



2. М.П.Мусоргский “Үзэсгэлэнгийн зураг” цувралаас



www.google.com



www.google.com



- Шүлгийг уншаад гол дүрийг дотроо дүрслэн бодоцгооё.
- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Хөгжимд жижигхэн бие, ихэмсэг зантай бяцхан одойн дүрийг хэрхэн илэрхийлсэн бэ?
- Зургийг ажиглаад тухайн хөгжмийн зэмсэг хэрхэн эгшиглэдгийг сонсож таниарай.

- Хүчдэлийн “*P*” тэмдгээр ямар дүр дүрслэлийг илэрхийлсэн бэ?
- Черноморийн ихэмсэг бардам дүрийг илэрхийлэхэд ямар хүчдэлийг ашиглаж байна вэ?

М.И.Глинка

ЧЕРНОМОРЫН МАРШ


Тахир сэлмээ толь шиг гялалзуулж
 Тун ч додигор алхаж явна
 Уран хийцтэй дэрэн дээр
 Урт буурал сахал дамнажээ
 Урт сахлын одой эзэн
 Урсах цувааны хойноос дагажээ
 Тэр хүн харцаа өргөж
 Дээдэс ихсийн маяг гаргажээ
 Богинохон бие нь бөгтөр юм гэнэ
 Босоо малгай өмссөн байв гэнэ.




Үлээвэр хөгжмийн хүчирхэг дуурьсал шидтэний хаан Черноморын албат зарц нараа дагуулан сүр бараатай ирж байгааг зарлан тунхаглана. Черномор бол зохиолын эсрэг талын дүр. Жижигхэн биедээ ахадсан уртаас урт сахалтай, инээд хүрэм ихэмсэг дээрэнгүй дүр төрхтэй, муу санаат шунахай сэтгэлтэй нэгэн. Черномор ямар ч хүчтэй баатрыг залилан дийлдэг байжээ. Тэрээр гоо үзэсгэлэнт Людмила, эрэлхэг хөлөг баатар Руслан хоёрыг хурим хийж байхад нь илбийн хүчээр Людмилаг хулгайлан авч оддог. Муу санаат Черноморыг даран устгаж, өөрийн сүйт бүсгүйг чөлөөлөхийн тулд Руслан олон бартаа саадыг даван туулна. Черноморын шидэт хүч түүний уртын урт сахалд байсныг Руслан олж мэдэн түүнийг даран устгаснаар тэд амар сайхандаа жаргадаг. Хөгжмийн зохиолч хүчдэлийн ялгааг маш чадварлаг ашиглаж Черноморын ихэмсэг гадаад дүр төрхийг тод томруун дүрсэлсэн.



Нарийн бүрээ



Царгил



Нарийн бүрээ

Хөгжим ямар ч дүрийг бүтээх увидастай. Аливаа дүрийг бүтээхэд эгшиг, аялгуу, цомнол, өнгө аяс, хэмнэл, хурд, хүч гэх мэт хөгжмийн хэлний хэрэглүүрүүд чухал үүрэг гүйцэтгэдэг.



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Ямар хөгжмийн зэмсгээр гоцлон хөгжимдсэн бэ?
- А Б А гэсэн бүтэц хөгжмийн ямар хэлбэрийг илэрхийлж байна вэ?

Б.Дамдинсүрэн

ХЭНТИЙН ӨНДӨР УУЛАНД

Оршил



www.google.com

Largo

Хэнтий Хангай Саяны өндөр сайхан
нуруунууд
Хойд зүгийн чимэг болсон ойн хөвч
уулнууд
Мэнэн Шарга Номины өргөн их говиуд
Өмнө зүгийн манлай болсон элсэн
манхан далайнууд

Төрөлх нутгаа гийгүүлсэн
Нарны туяанд хайртай би
Төвшин талдаа цуурайтсан
Эгшигт дуунд дуртай би



A

www.google.com

Allegro

Б




www.google.com

Andante

Уурга барьсан малчин залуус
Урагш хойш сүргийн зүг давхилдаад
Уртын дууг уран хөгөөр
Уруул исгэрч наадна

Ус ургамал жигдрэн
Үзэсгэлэнгийн охь болж
Баясгалангийн цог нэгдэж
Үнэхээр сүр жавхлан
Гуа гайхамшиг бүрджээ



A

www.google.com

Allegro



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.

М.П.Мусоргский


БЯЦХАН АНГААХАЙН БҮЖИГ

Оросын суут хөгжмийн зохиолч М.П.Мусоргский, зураач А.Гартманы уран бүтээлийн үзэсгэлэнг үзэж, түүний зургуудаас төрсөн сэтгэгдлээ буулган “Үзэсгэлэнгийн зургууд” нэртэй хөгжмийн зохиолоо бичжээ. Тэрээр зураачийн зурсан зургуудын утга санааг хөгжмийн хэлээр дүрсэлсэн байна. Бяцхан ангаахайнуудын шулганах дуун, тэнцэж ядан гүйх гэж оролдон бүдчих зугаатай дүр зургийг хөгжмөөр дүрслэн илэрхийлжээ.



- Зохиолыг анхааралтай сонсоод, бяцхан ангаахайнуудыг дуурайн бүжиглэе.
- Хоёр харандаа бэлтгээрэй.
- Харандаагаа хоёр гартаа бариад зургийн дагуу хөгжмийн аянд тохируулан “Харандаан бүжиг” хийцгээе.


ХАРАНДААН БҮЖИГ



1. Ангаахай хоёр хөлөө ээлжлэн өргөж үсэрснэ.



2. Ангаахайнууд хөөцөлдөн хөнгөн гүйнэ.



3. Ангаахай хоёр хөлөөрөө ээлжлэн газар самардана.



4. Ангаахай хоёр хөлөө ээлжлэн сэгсэрснэ.



5. Хоёр хөлөө салгаж нийлүүлэн үсэрснэ.



Дасгал 1

- Дараах аялгуу хэдэн хэсэгтэй байна вэ? Тэмдэглэгээг бичээрэй.
- Ноотыг ажиглаад хэмнэлээр тогшоорой.
- Багштайгаа хамтран хоёр хоолойгоор хөгжимдөөрэй.

А

Б

А

- Ноотоор хөгжимдье. Ингэхдээ тусгайлан тэмдэглэсэн хэсгүүд дэх хурууны байрлалын шилжилтийг анхаарч хөгжимдөөрэй.

Ая. Ц.Сүхбаатар

ЖИГМЭД ТОГМИД ХОЁР



БҮЖИГЛЭЭ

ХОСООРОО БҮЖИГЛЭЭ (Хөгжимт хөдөлгөөн)

- Ая.С.Ганчимэг “Хүүхэд нас” дууны аялгууны хэмнэлд тохируулан хосоороо бүжиглэж сураарай.



Бэлтгэх байдал



Дээрх хөдөлгөөнийг 4 тоонд дуурайж хийнэ.



Дороо гүйнэ.
(4 тоонд)



Охид хөвгүүд урагшаа 4 тоонд, хойшоо
4 тоонд зэрэг гүйнэ.



Эхлээд, баруун тийш
эргээд алгаа ташаарай.
(4тоонд)



Дараа нь зүүн тийш
эргээд алга ташаарай.
(4 тоонд)



Өөд өөдөөсөө гүйх ба
хөдөлгөөнийг эхнээс нь
давтана.



ХҮНДЭТГЭЛИЙН БҮЖИГ (хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмийн уран илэрхийллийн аргыг мэдэрч, ихэмсэг хүндэтгэлтэй байдлаар бүжиглээрэй.



Баруун - зүүн - баруун,
зүүн - баруун - зүүн гэсэн
дарааллаар хавсралттай
алхалтаар явна.



Зүүн тийш хагас эргэн,
хөвгүүд гараа нуруундаа
авч, охид зүүн гарыг дээш
өргөнө.



Зүүн хөлийг өлмийгөөр
урагш тавьж, бага зэрэг
бөхийн ёсолно.



Өөд өөдөөсөө харан
баруун гараа бариад
дороо алхалт хийнэ.



Зүүн хөлөөсөө арагш алхалт
хийж, бага зэрэг тонгойж
ёсолно.



Охид хөвгүүд хоёр тийш
эргэн бөхийн ёсолно.



Баруун гараасаа бариад
тойргоор алхана.



Гар гараасаа бариад бие биендээ
хүндэтгэл илэрхийлж ёсолно.



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ

Дасгал 1

- Тогтонги, тайван дүр зураг, эрс тэс ялгаа, эрчимтэй хөдөлгөөнийг хөгжимд хэрхэн илэрхийлэх вэ?
- Хүч, хурд, өнгө, эгшиг хэмнэлийн сонголт хийгээрэй.

№	Хөгжмийн дүр Хөгжмийн хэл	Тогтонги тайван хөдөлгөөн	Эрс тэс, эрчимтэй хөдөлгөөн
1.	Эгшиг		
2.	Өнгө аяс		
3.	Хэмнэл		
4.	Хурд		
5.	Хүч		

Дасгал 2

- Телевизийн нэвтрүүлэг, кино үзэж байхдаа хөгжмийг нь сайн сонсоорой.
- Тэдгээрт хөгжим ямар үүрэг гүйцэтгэж байна вэ? Ярилцаарай.


МЭРГЭЖИЛ БҮХЭН САЙХАН

- Барилгачин, будагчин, тоосго өрөгч, мужаан гэх мэт ажил мэргэжлийн онцлогийг харуулсан хөдөлгөөн зохиож бүжиглээрэй.
- Аялгууны шинж төрхөөс шалтгаалж бүжгүүд уянгын, инээдмийн, эрчимтэй, эсвэл түгшүүртэй ч байж болно.
- Юуны өмнө бүжгийн хөдөлгөөн нь хөгжмийн хэмнэлтэйгээ таарч байх ёстой. Мөн хөгжмөө тун анхааралтай сонсож сэтгэл хөдлөлөө илэрхийлэх шаардлагатай.



Дасгал 3


- Зураглалыг ажиглаарай.
- Долгион зураасын өндөр харилцан адилгүй байгаа нь юу илэрхийлж байна вэ?
- Шугамын дагуу аялгуу зохиогоорой.






Дасгал 4

- Дараах дүрст тэмдэглэгээг нэрлээрэй.



Дасгал 5



- Зургийг сайтар ажиглаад, хөгжмийн зэмсгүүдийг хэрхэн нэрлэдгийг интернэт болон толь бичиг ашиглан мэдэж аваарай.





ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

- Дараах тэмдгүүдийг нэрлээд үүргийг ярилцаарай.



- Загварын дагуу шоо бүтээгээрэй.
- Шооны талууд дээр эгшгийн нэрүүдийг үсгээр тэмдэглэнэ.
- Шоогоо орхиж буусан эгшгийг үеэр нэрлэж дэвсгэр шугамд хөрвүүлэн бичээрэй. Энэ бол чиний зохиосон хөгжмийн бүтээл.
- Янз бүрийн хэмжээтэй ноот бүхий шоог дээрхийн адил орхиж хэмнэлийн зураглал зохиогоорой. Зохиосон хэмнэлээ хөгжимдөж сонсоод нэр өгөөрэй.

